



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Өмнөдэлгэр сум

**Агаарын бохирдлын эх үүсвэрийн
нэгдсэн тоо бүртгэл зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.5 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.1, 27.2 дахь заалт, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2018 оны А/479 дүгээр тушаалаар батлагдсан “Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл хийх журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Л.Баярмаа	Засаг даргын Тамгын газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Ц.Отгонзул	Цаг уур өртөөний техникч
Гишүүд:	Багийн Засаг дарга нар	
	Т.Чинхуяг	Байгаль орчны хяналтын улсын байцаагч
	Байгаль хамгаалагчид	
	Б.Наранбаатар	Шуурхай үйлчилгээ, засварын техникч

2.Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тооллогыг 2026 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр хүртэлх хугацаанд холбогдох журмын дагуу зохион байгуулсугай.

3.Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийг зохион байгуулах удирдлага, мэргэжил арга зүйгээр хангаж, дүн мэдээг тогтоосон хугацаанд тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Л.Баярмаа)-д үүрэг болгосугай.



Р.ЭНХТӨР

2325310002
D:\disk\bichig hereg/ zahiramj/